

Мэдээ тайлан ирүүлэх, эргэх холбоо:

1. Дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан нэгдсэн удирдлага бүхий ажлын хэсэг хоёр долоо хоног бүрийн сүүлийн 7 хоногийн Пүрэв гаригт хуралдаж удирдамжид заагдсан ажиллах чиглэлийн дагуу хийсэн ажлын мэдээлэл солилцож, ажлаа уялдуулах ба шаардлагатай тохиолдолд шуурхай хуралдана.

2. Дэд ажлын хэсгүүд 14 хоног тутамд хуралдаж, хийгдсэн ажлын чиглэлээр мэдээлэл солилцож, Ажлын хэсгийн даргыг мэдээллээр хангаж ажиллана.

3. Ажлын хэсгүүд сар бүрийн сүүлийн 7 хоногийн Лхагва гаригт Улаанбаатар хотын Шуурхай удирдлага зохицуулалтын төвд тухайн сард ажилласан ажлын тайлан, мэдээгээ хүргүүлж, ажиллана.

4. Ажлын тайлан мэдээнд дараах мэдээллүүд орно:

- Хяналт, шалгалт хийж, мэдээлэл өгсөн аж ахуйн нэгж, байгууллагын тоо, нэрсийн жагсаалт
- Үүрэг даалгавар биелүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагын тоо, нэрс
- Шаардлага биелүүлдэггүй аж ахуйн нэгж, байгууллагын тоо, нэрс
- Ажлын хэсгийн товч тайлан /A4 хэмжээтэй 1 хуудаснаас хэтрэхгүй, 12 фонтод, 2-4 фото зураг/